



I-Х/2022

Тархаасан: 2022 оны 10 дугаар сарын 14



Объектын түймэр 2022 оны эхний 9 сарын байдлаар 2281 удаа бүртгэгдсэн байна

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2022 оны эхний 9 сарын байдлаар 3164 болж, өмнөх оны мөн үеэс 307 (10.7%)-гоор өссөн байна. Объектын түймэр 2022 оны эхний 9 сарын байдлаар 2281 удаа бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 434 (23.5%)-өөр, биологийн гаралтай аюулт үзэгдэл 169 болж, 113 (3.0 дахин их)-аар тус тус өссөн байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны эхний 9 сарын байдлаар нийт 216 хүн амь насаа алдаж, өмнөх оны мөн үеэс 53 (19.7%)-аар буурсан байна.

ХҮСНЭГТ 1. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ², жил бүрийн эхний 9 сарын байдлаар

Үзүүлэлт	2019 I-Х	2020 I-Х	2021 I-Х	2022 I-Х	2022 I-Х
					2021 I-Х
					хувь
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	3 896	3 127	2 857	3 164	110.7
Газар хөдлөлтийн тоо	29	44	277	53	19.1
Объектын түймрийн тоо	3 274	2 315	1 847	2 281	123.5
Амь насаа алдсан хүний тоо	171	208	269	216	80.3
Учирсан хохирол, тэрбум төгрөг	45.8	108.2	19.0	26.7	140.5
Зарцуулсан зардал, сая төгрөг	1 061.6	258.5	1 082.1	3 055.1	2.8 ¹

¹ - Дахин их

² - Корона вируст халдварын тохиолдлын тоо болон түүнтэй холбоотой гарсан зардлыг оруулаагүй.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны эхний 9 сарын байдлаар 26.7 тэрбум төгрөгийн хохирол учирч, 3.1 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Ойлголт, тодорхойлолт

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.



Эх үүсвэр:

Онцгой байдлын ерөнхий газар;

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 11 дүгээр сарын 13

Эдийн засгийн статистикийн
газрын дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн
газрын ахлах статистикч Б.Уянгаа
Утас : (976-51)-261563

